



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 6 сарын 29 өдөр

Дугаар 259

Улаанбаатар хот

### Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИК актив арван зургаа” ХХК-ийн гаргаж буй 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 30 хүртэл жилийн хугацаатай, орон сууцны зээлээр баталгаажсан нийт 1,170,673 /нэг сая нэг зуун далан мянга зургаан зуун далан гурав/ ширхэг хүртэлх баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. Баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын 1-д заасан нөхцөлөөр үнэт цаас гаргагчид ирүүлсэн хөрөнгө оруулагчдын захиалгын гэрээний дагуу худалдахыг “МИК актив арван зургаа” ХХК /Н.Батнасан/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “МИК актив арван зургаа” ХХК /Н.Батнасан/-д үүрэг болгосугай:

1/ Санхүүгийн зохицуулах хороо нь энэхүү тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэн нь тухайн үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв, эрсдэлгүй гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв тухайн баталгаат үнэт цаасанд эрсдэл үүсвэл Санхүүгийн зохицуулах хороо хариуцахгүй болохыг мэдэгдэхийн хамт энэ талаар үнэт цаасны танилцуулгад тусгайлан тэмдэглэж хөрөнгө оруулагчдад мэдээлэх;

2/ Энэ тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан уг үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багц дахь үл хөдлөх хөрөнгийг Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн хамтарсан А/167/203 тоот тушаалаар баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийх, бүртгэх тухай журам”-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн байгууллага дахь барьцааны бүртгэлд бүртгүүлж, энэ талаар 4 сарын дотор Санхүүгийн зохицуулах хороонд эргэж мэдэгдэх;

E:\ajil 2018\Blank\Togtool.doc

000552



3/ Баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг 30 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөр төлөх, мэдээллээр хангах болон бусад үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллах.

4. Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг “МИК ОССК” ХХК /Б.Гантулга/-д үүрэг болгосугай:

1/ Баталгаат үнэт цаасаар баталгаажсан зээлийн багцад буй зээлдэгчдийг Хорооны 2017 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ын дагуу ипотекийн даатгалд бүрэн хамруулах;

2/ Хороонд судалгаа, шинжилгээнд шаардлагатай холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр гаргаж ирүүлэх;

3/ Анх бүртгүүлсэн барьцаа хөрөнгийн үнэлгээний нийлбэр дүн, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны урт хугацаатай өглөгийн дүн, үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтийн талаарх мэдээллийг сар бүр тогтмол Хороонд ирүүлж байх.

5. Энэхүү тогтоолын 2-т заасан гэрээний дагуу үнэт цаас худалдан авсан хөрөнгө оруулагчдын үнэт цаасны өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэх, бүртгэлийн талаарх мэдээллийг улирал бүр гарган ирүүлж ажиллахыг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Монголбанк /Н.Баяртсайхан/, Сангийн яам /Ч.Хүрэлбаатар/-нд дараах арга хэмжээ авч ажиллахыг тус тус зөвлөсүгэй:

1/ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгч банканд Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд тогтмол хяналт тавьж ажиллах;


2/ Банканд олгосон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн зориулалт, ашиглалт, эргэн төлөлтөд тавьж буй хяналт шалгалтын тайлан, мэдээг Хороонд ирүүлэх;

3/ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүжилтийн эх үүсвэрийн зардлыг төсөвт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэж, зах зээлийн зарчмаар хөгжүүлэх чиглэлд анхаарал хандуулан ажиллах.

7. Энэ тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв эсэхийг үнэт цаас гаргагч “МИК актив арван зургаа” ХХК /Н.Батнасан/, хөрөнгө итгэмжлэн удирдагч “МИК ОССК” ХХК /Б.Гантулга/ болон энэ тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий анхны үүрэг гүйцэтгүүлэгч 10 арилжааны банк хариуцахыг дурдсугай.

8. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 259 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт


УХА0410 5043239

“МИК актив арван зургаа” ХХК-ийн гаргаж буй орон сууцны зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас

Баталгаат үнэт цаасны төрөл	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ /төгрөгөөр/	Эзлэх хувь
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас	100,000	1,053,604	4.5%	30 хүртэл жил	105,360,400,000	90%
Энгийн баталгаат үнэт цаас	100,000	117,069	10.5%	30 хүртэл жил	11,706,900,000	10%
Нийт	100,000	1,170,673	-	-	117,067,300,000	100%



Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 259 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



“МИК актив арван зургаа” ХХК-д орон сууцны зээл багцлан худалдаж буй анхны үүрэг гүйцэтгүүлэгчид

№	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Зээлийн багц хөрөнгө /төгрөг/	Зээлийн дансдын тоо	Нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээ
1	“Капитал банк” ХХК	3,539,419,870.30	58	3.02
2	“Капитрон банк” ХХК	2,781,461,817.25	42	2.38
3	“Чингис хаан банк” ХХК	550,974,524.84	10	0.47
4	“Голомт банк” ХХК	20,889,214,610.88	394	17.84
5	“Хаан банк” ХХК	31,676,831,957.34	509	27.06
6	“Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК	964,179,501.76	16	0.82
7	“Төрийн банк” ХХК	15,066,428,643.17	290	12.87
8	“Худалдаа хөгжлийн банк” ХХК	18,994,800,718.75	293	16.23
9	“Улаанбаатар хотын банк” ХХК	13,276,051,476.34	190	11.34
10	“Хас банк” ХХК	9,328,398,348.77	177	7.97
	<b>Нийт</b>	<b>117,067,761,469.40</b>	<b>1,979</b>	<b>100.0</b>